

- гишүүдийн санал гомдлын дагуу Холбооны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг шалгах зэрэг эрхийг хэрэгжүүлнэ.
- 5.44. Хяналтын зөвлөлийн гишүүн нь тамирчин, дасгалжуулагч, шүүгч, мэргэжилтэн, эрдэмтэн судлаач, эсхүл эрх зүй, санхүүгийн мэргэжилтэй хувь хүн байна.
- 5.45. Хяналтын зөвлөл нь бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнана.

### Мэргэжлийн зөвлөл

- 5.46. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Удирдах зөвлөлөөс тогтооно. Мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон даргыг Удирдах зөвлөлийн хурлаас Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн хэлэлцэж 2 жилийн хугацаатай томилно.
- 5.47. Мэргэжлийн зөвлөл нь дараахь эрх хэмжээтэй байна.
- 5.47.1. Холбооны удирдлага, түүний байнгын тогтвортой ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;
- 5.47.2. Уулын спортын тэмцээн, уралдаан, зохион байгуулалтын явцад гарсан маргаан, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүй, сахилга баттай холбоотой гомдлыг шийдвэрлэх;
- 5.47.3. Шигшээ баг бүрдүүлэх, тэмцээн уралдаанд оролцох баг бүрэлдэхүүнийг /тамирчин, дасгалжуулагч/ сонгох, дасгалжуулагчдын ажиллах арга барилд зааварчилгаа өгөх, шигшээ багийн бэлтгэлийн норм төлөвлөгөөг хянан хэлэлцэж удирдах зөвлөлд танилцуулах;
- 5.47.4. Холбооны удирдлагад санал оруулах, зөвлөх, бодлого чиглэл тодорхойлоход оролцох.
- 5.48. Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь уулын спортын мастер болон түүнээс дээш зэрэгтэй тамирчин, багш, дасгалжуулагч, мэргэжилтэн эсхүл спортын чиглэлээр эрдмийн ажил туурвисан эрдэмтэд байна.
- 5.49. Мэргэжлийн зөвлөл нь маргааныг бичгээр хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 5.50. Гомдол гаргагч нь мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл удирдах зөвлөлд хандаж шийдвэрлүүлнэ. Удирдах зөвлөлийн шийдвэр эцсийнх байх бөгөөд үүнийг гишүүн бүр биелүүлэх үүрэгтэй.
- 5.51. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гишүүн бүр хуралдаанд тэгш эрхтэй оролцоно.
- 5.52. Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан нь нийт гишүүдийн олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 5.53. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг удирдах зөвлөл тогтооно.
- 5.54. Холбоо нь удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу шүүгчдийн, дасгалжуулагчдын, тамирчдын зэрэг дагнасан орон тооны бус зөвлөлийг томилон ажиллуулж болно.

### Ёс зүйн зөвлөл